

РХА-ИЙН МОНТЕР-III ЗЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН АСУУЛТ

1-Р ХЭСЭГ

1. Ажлын программ боловсруулах шаардлагагүй РХА-ийн жагсаалтыг хэн батлах вэ?
 - a. РХА-ийн албаны дарга.
 - b. Гүйцэтгэх захирал.
 - c. Байгууллагын ерөнхий инженер.
2. Дэд станц ЦШС-ний хүчний цахилгаан тоноглолуудад реле хамгаалалт, автомат таслуур, гал хамгаалагч ямар зорилгоор тавигддаг вэ?
 - a. богино залгаа ба хэвийн горим алдагдахаас хамгаалах
 - b. хүчдэлд хүн нэрвэгдэхээс хамгаалах
 - c. цахилгаан ачаалал хэтэрч тоноглол гэмтэхээс хамгаалах
3. Аль нь хугацаанаас хамаарсан гүйдлийн эрхтэн бэ
 - A. 50Pn
 - B. 51Pn
 - C. 51Nn
4. Шугамын хамгаалалтыг нэрлэнэ үү?
 - A. SEL-587
 - B. SEL-551
 - C. SEL-311
5. SEL-551 реле хэдэн оролтой вэ?
 - A. 3
 - B. 2
 - C. 4
6. SEL-551C реле хэдэн гаралтай вэ?
 - A. 3
 - B. 2
 - C. 4
7. Микропроцессорын хамгаалалтаас гүйлдийн параметр харахад ямар товч ашигладаг вэ?
 - A. Meter/Cancel
 - B. Status
 - C. Other
8. Аль нь трансформаторын хамгаалалт вэ?
 - A. SEL-587
 - B. SEL-551
 - C. SEL-311
9. Аль нь МТЗ хамгаалалт бэ
 - A. 50Pn
 - B. 51Pn
 - C. 51Nn
10. Шугамын хамгаалалтыг нэрлэнэ үү?
 - A. CDA-901
 - B. GKP-392
 - C. SEL-311
11. Аль нь трансформатор үндсэн хамгаалалт вэ?
 - A. Хийн, дифференциал
 - B. Хийн, МТЗ
 - C. Дифференциал, МТО
12. Шугамын хамгаалалт аль нь вэ?
 - A. МТО, МТЗ, газардлагын
 - B. Хийн, дифференциал
 - C. дифференциал
13. РХА-ийн байгууламжид ашиглалтын явцад гэмтэл илэрвэл ямар арга хэмжээ авах вэ?
 - a. Илэрсэн гэмтлийг нэн даруй арилгадаг байвал зохино.
 - b. Илэрсэн гэмтлийг нэн даруй арилгахын тулд удирдлагадаа мэдэгдэнэ.
 - c. Дээрх 2 хариулт бүгд зөв.
14. Трансформатор ачаалалтай байхад хүчдэлийн тохируулагч ямар горимд байх ёстой вэ ?
 - a. халаагуур залгасан байна
 - b. хэвийн
 - c. автомат
15. Хамгаалалтуудын зарим нь гэмтэх буюу ажлаас гаргасан үед ажиллагаанд үлдсэн бусад реле хамгаалалтын байгууламжуудад ямар шаардлага тавигдах вэ?
 - a. Цахилгаан тоноглол ба шугамын бүх төрлийн гэмтлийг шуурхай арилгах ёстой.
 - b. Цахилгаан тоноглол ба шугамыг бүх төрлийн гэмтлээс бүрэн хамгаалж чадахаар байх ёстой.
 - c. Сонгох чадвар өндөр байх ёстой.
16. Түргэн үйлчилгээтэй реле хамгаалалт ба бэлтгэл хамгаалалттай шугам, шин, тоноглолын тосон таслуурт засвар хийсний дараа дахин хүчдэл өгөхөд ямар шаардлага тавигдах вэ?

- a. Хуурай салгуур ба агаарын таслуураар хийх бүх үйлдлийг үйлдвэрийн ерөнхий инженерийн шийдвэрээр хийж гүйцэтгэнэ.
 - b. Хуурай салгуур ба агаарын таслуураар хийх бүх үйлдлийг хамгаалалтуудын ажиллагааг шалгасны дараа хийж гүйцэтгэнэ.
 - c. Хуурай салгуур ба агаарын таслуураар хийх бүх үйлдлийг хамгаалалтуудыг нь ажилд оруулсны дараа хийж гүйцэтгэнэ.
17. Хяналтын кабелийн сул чөлөөтэй байгаа судлын үзүүрүүдэд ямар шаардлага тавигдах вэ?
- a. Сул үзүүрүүдийг задгай орхихыг хориглоно.
 - b. Сул үзүүр үлдээхийг хориглоно.
 - c. Хөндийрүүлсэн байх ёстой.
18. Хүчний цахилгаан тоноглол ба цахилгаан дамжуулах шугамыг ямар нөхцөл хангагдсан бол хүчдэлд залгаж болох вэ
- a. бүх төрлийн реле хамгаалалтууд залгагдсан нөхцөлд
 - b. Комисс ажилласан нөхцөлд
 - c. Диспетчер инженерийн зөвшөөрөл өгсөн нөхцөлд
19. ИХБ-ын аянга зайлцуулагч, прожекторын багана, утааны яндан зэргийг ашиглан 1000 В хүртэлэх агаарын шугамын утас татаж болохуу?
- a. сайн бэхэлгээ хийсэн байх ёстой
 - b. Болно
 - c. Болохгүй
20. Хүчний цахилгаан тоноглол ба цахилгаан дамжуулах шугам нь дараах нөхцөлд хүчдэлтэй байж болно.
- a. Бүх төрлийн реле хамгаалалтууд нь залгахад бэлэн нөхцөлд.
 - b. Бүх төрлийн реле хамгаалалтууд нь залгагдсан нөхцөлд.
 - c. Реле хамгаалтаас хамаарахгүй.
21. РХА-ийн тавилыг хэн өөрчилж болох вэ ?
- a. диспетчер инженер
 - b. ашиглалтыг хариуцсан хүмүүс
 - c. ШҮЗ-ын техникч буюу монтёр
22. Нэг шуудуунд хэдэн кабелийг хийж булах вэ?
- a. 2-иос илүү хийхийг хориглоно
 - b. 4-өөс илүү хийхийг хориглоно
 - c. 6-аас илүү хийхийг хориглоно
23. Реле хамгаалалтанд тавигдах шаардлага аль вэ
- a. Мэдрэч ажиллах, сонгох чадвар, найдвартай, хурдан ажиллагаа
 - b. Шаардалага тавигдахгүй
 - c. Сонгох, мэдрэх, найдвартай, хурдан
24. Заагч реле ямар зориулалттай вэ?
- a. тогтмол гүйдлийн хэлхээнд реле хамгаалалт автоматикийн байгууламж ажилласныг заах
 - b. Тогтмол гүйдлийн хэлхээнд ямар хамгаалалт ажилласныг заах
 - c. Ямар хамгаалалт ажилласныг зааж дүн шинжилгээ хийхэд хялбар болгоно.
25. РТ ямар төрлийн реле вэ
- a. Хугацааны
 - b. Гүйдлийн
 - c. Хүчдлийн

2-Р ХЭСЭГ

1. Трансформатор буюу хувьсгуур гэж юу вэ?
 - a. Нэг хүчдлийн түвшинг нөгөө түвшинд шилжүүлнэ.
 - b. Их хүчдлийн түвшинг багасгана
 - c. Бага хүчдлийн түвшинг ихэсгэнэ.
2. Трансформаторын тосны үүрэг
 - a. Трансформаторын тос хөндийрүүлэг ба хөргөлтийн үүргийг гүйцэтгэнэ
 - b. Трансформаторын эд ангийг зэврэлтээс хамгаална
 - c. Трансформаторын жинг тэнцвэржүүлэх

г. Агаарын даралтаас хамгаалан эд ангийг гадны нөлөөлөлд автхааас сэргийлнэ.

3. Цахилгаан хөдөлгөгч хүчийг аль томьёогоор олох вэ?

- a. $\alpha = (R_2 - R_1) / (R_1 (t_2 - t_1))$
- b. $R = \rho * L / S$
- c. $U = \varphi A - \varphi B$
- d. $E = A/q$

4. Цахилгаан эсэргүүцэл гэж юу вэ?

- a. Дамжуулагчийн дотор цахилгаан цэнэгүүд шилжихэд саад болж байгаа эсрэг үйлчлэх хүчийг хэлнэ
- b. Зөвхөн тэжээл үүсгэгчийг багтааж байгаа хэлхээний хэсгийг хэлнэ
- c. Цахилгаан орны хүчиний үйлчлэлээр цахилгаан хэлхээнд цэнэгүүдийн журамлагдсан чиглэлт хөдөлгөөн бий болохыг хэлнэ.

5. Цахилгаан хөдөлгүүр гэж юу вэ?

- a. Цахилгаан энерги яшиглан механик энерги бий болгодог төхөөрөмж юм
- b. Механик энергигийг цахилгаан болгон хувиргадаг төхөөрөмж юм
- c. Ямар нэгэн энергигийг өөр энергиgid хувиргадаг төхөөрөмж бүрийг цахилгаан хөдөлгүүр гэж ойлгож болно.

6. Цахилгааны хэмжүүрийн багажийг ажиллах зарчмаар нь:

- a. Соронзон цахилгаан, Цахилгаан соронзон , Цахилгаан динамик
- b. Термоцахилгаан, Цахилгаан статик, Электроны
- c. Цахилгаан соронзон,Индукцийн, Цахилгаан статик
- d. Аль нь ч биш
- e. Бүгд зөв

7. Тэжээл үүсгэгчийн ЦХХ үйлчилж байгаа битүү хэлхээнд хэлхээний эсэргүүцлээс хамааруулаад гүйдлийн хэмжээг тогтоож болдог. Энэ ямар хуульд хамаарах вэ?

- a. Киркофийн хууль
- b. Ленцийн хууль
- c. Парадейн хууль
- d. Омын хууль

8. Цахилгаан орны хүчиний үйлчлэлээр цахилгаан хэлхээнд цэнэгүүдийн журамлагдсан чиглэлт хөдөлгөөн бий болох үзэгдэлийг юу гэх вэ?

- a. Цэнэг
- b. Соронзон орон
- c. Гүйдэл
- d. Хүчдэл
- e. Аль нь ч биш

9. Автомат болон пускателийн ялгаа

- a. Адил
- b. Нэг нь удирдах болон хамгаалах ба ногөө нь хүчдэл таслана
- c. Хүчдэлийг таслана
- d. Хүчдлийн түвшингээрээ ялгаатай

10. Шуурхай сэлгэн залгалт гэж юу вэ?

- a. Хурдан хугацаанд хийгдсэн сэлгэн залгалтыг хэлнэ
- b. Тухайн үед ямар нэгэн зөвшөөрөл авалгүй хийгдэх сэлгэн залгалтыг хэлнэ
- c. Бэлтгэлд байгаа тоноглолыг ажилд залгахыг хэлнэ
- d. Бүгд зөв

11. ОРУ гэж юу вэ?

- a. Ямар нэгэн хөдөлгүүрийн удирдлагын байрлах өрөө тасалгааг хэлнэ
- b. Ил хуваарилах байгууламж
- c. Хаалттай хуваарилах байгууламж
- d. Аюултай байж болох гэрэлтүүлэг хангалтгүй газар доорхи байгууламж

12. Амгалан дулааны станцын 10кВ тэжээлийн кабелийн тойргийн хэмжээ хэд вэ?

- a. 110 ,10
- b. 0,4 , 10
- c. 240 ,195
- d. 120 , 85

13. Хамгийн их ачаалал авдаг хөдөлгүүр аль нь вэ?

- a. Утсаа сорогч
- b. Буцаах салхилуур
- c. Анхдагч салхилуур
- d. Бутлуур

14. Инвертор болон конвейрторын ялгаа

- а. Хүчдэл ихсэлт болон фазын зөрүүг арилгах
- б. Хэт ачаалал болон хүчдэл багасалтаас хамгаалах
- в. Давтамжийг өөрчлөх болон хүчдэл тогтвортжуулах
- г. Ямар нэгэн онцын ялгаа байхгүй ба ажиллах зарчим адил хүчдлийн түвшингээс хамааруулан сонгоно

15. Хүчдэлд нэрвэгдсэн ажилтантай таараздвал хамгийн түрүүнд ямар арга хэмжээ авах вэ?

- а. 102 дуудаж дулаан хучиж орхих б. Татаж аван хиймэл амьсгaa хийх
- в. Ерөнхий инженерт мэдэгдэх г. Хүчдэлээс чөлөөлөх д. Бүгд зөв

16. Хүчдэлтэй цахилгаан хөдөлгүүрт хэдий хугацаанд чийгтэй цэвэрлэгээ хийх вэ?

- а. 7 хоногт 1-с доошгүй б. Өдөр бүр в. Улиралд 1 удаа г. Жилд 1 удаа д. Бүгд буруу

17. 10кВ хүчдэлд 10см ойртон ажиллах үеийн аюулгүй ажиллагаанд аль нь хамаарахгүй вэ?

- а. Хамгаалалтын бээлийг хэрэглэх
- б. Боть хэрэглэх
- в. Хөндийрүүлэх дэвсгэр хэрэглэх
- г. Бүгд зөв
- д. Болохгүй

18. Ажиллагаанд байгаа хөдөлгүүрийн фаз зөрсон эсэхийг хэрхэн мэдэх вэ?

- а. Хөдөлгүүрийн дуугаар
- б. Сэнсний чиглэлээр
- в. Доргиогоор нь
- г. Сорох болон үлээж байгаа эсэхээр

19. Хэт ачааллалд орсон хөдөлгүүрийн гол онцлог юу вэ?

- а. Доргиотой байх
- б. Халалттай байх
- в. Дуу ихтэй болох
- г. Хэт хүйтэн байх

20. Трансформаторын сэлгэгч РПН байгууламжийг тосны дээд үеийн температур хэдээс дээш байхад залгахыг хориглох вэ?

- а. -15С б. -30С в. -20С г. -45С

21. YKK4506-4 хөдөлгүүр ямар үүрэгтэй вэ?

- а. Анхдагч агаарын салхилуурын цахилгаан хөдөлгүүр
- б. Доргиогчийн хөдөлгүүр
- в. Алхан бутлуурын хөдөлгүүр
- г. хоёрдогч агаарын салхилуурын цахилгаан хөдөлгүүр

22. АВР гэж юу гэсэн үг вэ?

- а. Автоматаар дахин залгагч
- б. Автоматаар секц холбогч
- в. Автоматаар ачаалал таслагч
- г. Секц холбогч таслуур

23. АЧР гэж юу вэ?

- а. Ачаалал хөнгөвлөгч
- б. Автоматаар дахин залгагч
- в. Автоматаар сэлгэн залгалт хийх
- г. Автоматаар алдаа арилгагч

24. Газардуулгыг ямар дарааллаар тавих вэ?

- а. Тоноглолд сондгой үзүүрийг холбоод дараа нь хүрээ газардуулгад үлдсэн 3 үзүүрийг холбоно
- б. Аль нэг үзүүрийг тоноглолд холбон хүрээ газардуулгад үлдсэн аль нэг үзүүрийг холбоно
- в. Өөрт аль эвтэйгээр үйлдлийг гүйцэтгэнэ.
- г. Тоноглолд 3 үзүүрийг холбоод хүрээ газардуулгад үлдсэн үзүүрийг холбоно
- д. Хүрээ газардуулгад сондгой үзүүрийг холбоод тоноглолд 3 үзүүрийг холбоно

25. Ажиллагаанаас гаргаад удаагүй трансформаторт ажил гүйцэтгэхдээ нэн түрүүнд авах арга хэмжээ

- а. Задлаж цэвэрлэх
- б. Дамжуулагч щинийг салгаж авах
- в. Тосыг сулах
- г. Цэнэгийг шавахаа д. Газардуулах

26. Таслуур салгуурын ялгаа

- а. Онцын ялгаа байхгүй ба хүчдлийн түвшингээс хамааруулан сонгоно
- б. Ачаалалтай үед салгуурыг хэрэглэнэ, ачаалалгүй үед таслуурыг хэрэглэнэ
- в. Аль алийг нь ачаалалгүй үед хэрэглэнэ
- г. Ачаалалтай үед таслуурыг хэрэглэнэ, ачаалалгүй үед салгуурыг хэрэглэнэ.

27. Вакум таслуур тосон таслуурын ялгаа

- а. Вакум таслуур эхлэж ажиллах ба дараа нь тосон таслуур тасардаг
- б. Тосон таслуур эхлэж тасарна
- в. Үүргийн хувьд ялгаа байхгүй
- г. Вакум таслуур нум унтраах ба тосон таслуур ийм чадвар байхгүй

28. Асинхрон хөдөлгүүрийн онцлог

- а. Механик энергийг механик энерги чигээр нь ашиглана
- б. Цахилгаан энергийг механик энерги болгон хувиргана
- в. Механик энергийг цахилгаан энергид хувиргана
- г. Ус халаах төхөөрөмж

29. Турбин гинератор ямар төрлийн хөдөлгүүр вэ?

- а. Асинхрон б. Синхрон в. Усан хөргөлтөт г. Цахилгаан хөдөлгүүр

30. Нэгдсэн сүлжээ гэж юу вэ?

- а. 2 ба түүнээс дээш аймгийн төвийг хамран цахилгаан хангамжийн үйлчилгээг үзүүлэхийг хэлнэ
- б. хоорондоо холбогдсон эх үүсвэр дамжуулах сүлжээг хэлнэ
- в. хоорондоо холбогдсон эх үүсвэр болон түгээх сүлжээг хэлнэ
- г. Бүгд буруу
- д. Бүгд зөв

31. Хаалгтай хуваарилах байгууламжийн дотор агаарын хэм зуны улиралд хэд байвал зохимжтой вэ?
а. +20 б.+35 в.+40 г.+45

32. Хуваарилах байгууламжийн тоноглолын үзлэгийг харанхуйд хийх, цахилалтыг шалгах ажлыг хэдий хугацаанд хийх вэ?

- а. Улиралд 1-с доошгүй б. Сард 1-с доошгүй в. Жилд 1-с доошгүй г. 7 хоногт 1-с доошгүй

33. Ажлын байрны гэрэлтүүлгийн хэмжээ

- а.5люкс б.10люкс в.15люкс г.20люкс

34. Үндсэн тусгаарлах, хамгаалах хэрэгсэлд аль нь хамааралгүй вэ?

- а.Тусгаарлах штанг
- б.Гүйдэл хэмжих бахь (клещи)

- в.Хүчдэл заагуур
- г.Тусгаарлах бахь
- д. Ампер клейш

35. Цахилгаан станцуудын утааны яндангийн гадаад, дотоод үзлэгийг хэдий хугацаанд хийдэг вэ?
- а. Гадаад үзлэгийг нь жилд 1 удаа (хавар), дотоод үзлэгийг ашиглалтанд орсоноос 5 жилийн дараа, цаашид 10 жилд 1, 100м-ээс дээшихийг нь 5жилд 1удаа геодиз шалгалт хийлгэх хэрэгтэй
 - б. Гадаад үзлэгийг нь (хавар), дотоод үзлэгийг ашиглалтанд орсоны дараа, цаашид 100м-ээс дээшихийг нь 5жилд 1удаа геодиз шалгалт хийлгэх хэрэгтэй
 - в. Гадаад үзлэгийг нь (хавар), дотоод үзлэгийг ашиглалтанд орсоны дараа, цаашид 100м-ээс дээшихийг нь 5жилд 1удаа, геодиз шалгалт хийлгэх шаардлагагүй

36. Богино холбоот ротортой цахилгаан хөдөлгүүрийг халуун байдлаас хэдэн удаа залгаж болох вэ?
- а. Еронхий инженерийн шийдвэрээр залгаж болно
 - б. Элжийн инженерийн шийдвэрээр залгахыг хориглоно
 - в. 1 удаа залгана

37. 12-36В –ын зөөврийн трансформатор, гэрэлтүүлэгчийн хөндийрүүлэлтийн хэмжилтийг ямар хугацаанд хийх вэ?

- а. Трансформаторыг жилд 2 удаа, хөндийрүүлэгийг жилд 1 удаа
- б. Трансформаторыг жилд 1, гэрэлтүүлэгчийн хөндийрүүлэгийг жилд 2
- в. 12-36В-ын зөөврийн трансформаторын хөндийрүүлэг хэмжих шаардлагагүй, г.Гэрэлтүүлэгчийн хөндийрүүлэлтийг хэмжих шаардлагагүй

38. Цахилгаан станц, дэд станцын гол байр, төв ба блок удирдлагын щитүүд, түүнчлэн диспетчерийн байрууд дахь аваарийн үед асах гэрэлтүүлэгч нь үндсэн щитийн нүүрэн талд –ээс багагүй гэрлээр хангасан байх ёстой.

- а. 30лк-ээс багагүй
- б. 25лк-ээс ихгүй в.35лк болно
- г. 60лк-ээс багагүй
- д. 20лк-ээс их

39. Эргэх механизмын роторын эргэлтийн номиналь давтамж 8000эрг/мин үед доргионы давхар амплитудмкм-ээс хэтрэх ёсгүй вэ?

- а. 160мкм
- б. 150мкм
- в. 145мкм
- г. 165мкм

40. Цахилгаан тэжээл секунд хүртэл тасалдахад онц чухал механизмын цахилгаан хөдөлгүүр өөрөө явах нөхцлийг хангасан байна.

- а. 2,5
- б. 6,2,0
- в. 2,3
- г. 2,8
- д. 3,0

41. Нэг кабелийн муфт хоорондын зайд м байх ёстой вэ?

- а.45
- б.35
- в.50
- г.40

42. Засвар хоорондын хугацаанд тосон таслуурыг дамжуулгын нь хамт түүний тодорхойломжид хяналт тавьж байх үеджилд 1 удаа Их засвар хийнэ.

- а. 3-6 жилд
- б. 4 жилд
- в. 5-6 жилд
- г. 3 жилд
- д. 6-8 жилд

43. Тосон трансформаторт гүйдлийн хэт ачаалал 30% байхад минут ажиллуулж болно.

- а.125
- б.120
- в.130
- г. 135

44. Ил хутга бүхий тусгаарлагч, богино холбуур, тэдгээрийн дамжуулагад жилд 1 удаа Их засвар хийх вэ?

- а. 3-5 жилд
- б. 5 жилд
- в. 2-3 жилд
- г. 3 жилд
- д. 6-8 жилд

45. 220В-ын аккумуляторын батарейд хөндийрүүлэгийн эсэргүүцэлкОм-с багагүй байх ёстой вэ?

a.110кОм b.120кОм в.100кОм г.105кОм

III ХЭСЭГ

1. Ээлжинд ажиллагсад нь ажил эхлэхээс хэдэн минутын өмнө ажлын байранд ирэх вэ?
 - a. 1 цаг
 - б.15 минут
 - в. 30 минут
 - г. Заалт байхгүй.
 2. Ээлжийн ажиллагсад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажилдаа гарах боломжгүй болсон тохиолдолд хэсгийн удирдлагагад ямар хугацаанд мэдэгдэх вэ?
 - a. 8 цагийн өмнө
 - б. Ажил хүлээлгэн өгөхөөс өмнө
 - в. 4 цагийн өмнө
 - г. 1 цагийн өмнө
 3. Хөдөлмөрийн дотоод журманд зааснаар сахилгын шийтгэл ногдуулсанаас хойш ямар хугацаа өнгөрвөл уг ажилтыг сахилгын шийтгэлгүйд тооцох вэ?
 - a. 3 сар
 - б. 6 сар
 - в. 1 жил
 - г. 1 сар
 4. Ажил олгогч нь ажилтнаас ажил үүргээ биелүүлэхийг шаардаж болох уу?
 - a. Хууль зөрчсөн албадлагын шинж чанартай үйлдэл тул хуулиар хориглосон
 - б. Ажилтан гэрээ байгуулсан учир сайн дураар ажиллах эрхтэй.
 - в. Болохгүй
 - г. Болно
16. 5. Хөдөлмөрийн дотоод журамд зааснаар Ажлаас халах үндэслэл аль нь вэ?
- a. Компанийн эд хөрөнгийг дур мэдэн авсан, 400,000 төгрөгнөөс дээш хохирол учруулсан
 - б. Үгсэн хуйвалдсан, 400,000 төгрөгнөөс доош хохирол учруулсан
 - в. бүгд зөв
6. Дотоод журамд зааснаар “Ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан бол сарын болон жилийн үр дүнгийн шагналт цалин олгохгүй.”
- a. Зөв
 - б.буруу
 - в. Заалт байхгүй
7. Ажилтан санал хүсэлт, гомдлоо захирагаанд ямар хэлбэрээр тавьж шийдвэрлүүлэх вэ?
- a. Аман болон бичгээр
 - б. Заавал бичгээр
8. Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг ямар ажилтантай байгуулах вэ?
- a. Бүх ажилтантай
 - б. Зөвхөн эд хөрөнгө хариуцах ажилтантай
9. Сул зогсолтын үед ажилтанд юу олгох вэ?
- А. Нэмэгдэл цалин
 - б. Урамшуулал
 - В. Цалин хөлс
 - г. Олговор
10. Хөдөлмөрийн дотоод журамд хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтнуудыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах хугацааг юу гэж тодорхойлсон бэ?
- А. 1 жилд 2 удаа
 - б. Сул зогсолтын үеийн дараа ажил эхлэхийн өмнө
 - В. 6 сар тутам
 - г.2 жилд 1 удаа